



ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/58

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 46.2 дахь хэсэг, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус компанид автомашины зогсоолын өргөтгөл хийх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороог дараах бүрэлдхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дарга: Г.Болдсайхан
/Хангамж, үйлчилгээ хариуцсан дэд захирал/
Нарийн бичгийн дарга: М.Энхбат
/Худалдан авах ажиллагааны ахлах мэргэжилтэн/
Гишүүд: Э.Нямбаяр
/Аж ахуйн хэлтсийн ахлах мэргэжилтэн/
Ч.Сумьяа
/Монголын эрчим хүчний ассоциацийн гишүүн/
Ж.Ханд-Иш
/Монголын эрчим хүчний мэргэшсэн инженерүүдийн зөвлөлийн гишүүн/

2. Холбогдох хууль, тогтоомж, заавар, журмын дагуу тендерийн бичиг баримтыг бүрдүүлэн тендерийн ажиллагааг явуулж, үнэлгээний хорооны дүгнэлт, зөвлөмжийг захиалагчид танилцуулахыг үнэлгээний хорооны дарга /Г.Болдсайхан/-д үүрэг болгосугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлэх, Үнэлгээний хорооны гишүүдийн мэдэгдэл, тайлбарыг гаргуулан авч компанийн эрх бүхий албан тушаалтанд хугацаанд нь бүртгүүлэхийг нарийн бичгийн дарга /М.Энхбат/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



С.БЯМБААХҮҮ

Tushaal.A4.2019

360070338

